



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2021 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 08

Мандалговь

Дундговь аймгийн уул уурхай,  
эрдэс баялгийн салбарт баримтлах  
бодлого батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 з, е, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйл, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйл, УИХ-ын 2014 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс эрдэс баялгийн талаар баримтлах бодлого”-ын 3.5 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. “Дундговь аймгийн уул уурхай, эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын баримт бичгийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Бодлогыг хэрэгжүүлэх ажлыг аймаг, сумын жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллах, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын хандив, тусламж, төсөл хөтөлбөрт тусган ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат), сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Гурав. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Мөнгөнцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн  
08 дугаар тогтоолын хавсралт

**ДУНДГОВЬ АЙМГИЙН УУЛ УУРХАЙ, ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ  
БАРИМТЛАХ БОДЛОГО**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Дундговь аймгийн эдийн засгийн салбарт бэлчээрийн мал аж ахуйд суурилсан хөдөө аж ахуй, бөөний болон жижиглэнгийн худалдаа, хүнсний үйлдвэрлэл түүнчлэн гэр баазуудад түшиглэсэн аялал жуулчлал, цахилгаан эрчим хүч, усан хангамж, дулааны үйлдвэрлэл, ил аргаар олборлолт явуулж шууд ачуулдаг уул уурхайн үйлдвэрлэл зэрэг цөөн салбар голлох үүрэгтэй байна.

Геологи, уул уурхайн судалгаа, шинжилгээний ажлуудын үр дүнд газрын хэвлийн баялгаар багагүй нөөцтэй болох нь тогтоогдож, чулуун болон хүрэн нүүрс, хайлуур жонш, гөлтгөнө, төмөр, цайрын хүдэр, шатдаг занар, алт, мөнгө, уран, бал чулуу, эрдэс будаг, барилгын материалын зэрэг 33 нэр төрлийн ашигт малтмалын их, бага хэмжээтэй 81 орд, 149 илэрц олдож судлагджээ.

Уул уурхайн олборлолтын гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүд бол нүүрс, жонш, гөлтгөнө бөгөөд 2019 онд уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 4.6 тэрбумд хүрч өмнөх онтой харьцуулахад 26.3 %-аар өссөн үзүүлэлттэй байна. Гөлтгөнийн олборлолт биет хэмжээгээр 37.8 %-аар буурч, мөнгөн дүнгээр 232.4 %-аар өссөн бол нүүрсний олборлолт биет хэмжээгээр 14.7 %-аар буурч, мөнгөн дүнгээр 12.8 хувиар буурсан, жоншны олборлолт биет хэмжээгээр 42.9 %-аар буурч, мөнгөн дүнгээр 19.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Аймгийн нийт аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 39.1%-ийг уул уурхайн бүтээгдэхүүн олборлох үйлдвэрлэл, 13.1%-ийг боловсруулах үйлдвэрлэл, 47.9%-ийг дулаан, эрчим хүчний үйлдвэрлэл эзэлж байна.

2019 оны байдлаар Дундговь аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүн 380.9 тэрбум төгрөг байсан бол үүний 75 тэрбум нь буюу 19.7%-г аж үйлдвэрийн бүтээгдэхүүн эзэлж байна.

2020 оны 2 дугаар сарын 29-ний байдлаар Дундговь аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл 13 сумын нутагт 106, хайгуулын тусгай зөвшөөрөл 15 сумын нутагт 96, нийт 202 тусгай зөвшөөрөл бүртгэлтэй байна. Эдгээрийн талбайн хэмжээ 704,501.07 га буюу нийт нутаг дэвсгэрийн 9.4 хувийг эзэлж байна.

Ашиглалтын 106 тусгай зөвшөөрлийг 79 аж ахуйн нэгж эзэмшиж байгаагийн 26 нь жонш, 17 нь нүүрс /7 орд/, 11 нь гөлтгөнө /3 орд/, 9 нь барилгын материал, 9 нь төмөр, 3 нь алт, 1 перлит, 1 мөнгө, 1 өнгөт метал, 1 литий, 1 уран, 1 нь бал чулуу байна. Эдгээрийн 46 нь дотоодын, 11 нь хамтарсан, 16 нь гадаадын 100% хөрөнгө оруулалттай байна. Хайгуулын 96 тусгай зөвшөөрлийг 84 аж ахуйн нэгж эзэмшиж байгаагаас дотоодын 66, хамтарсан 10, гадаадын 100% хөрөнгө оруулалттай 8 аж ахуйн нэгж байна.

Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн хариуцлагагүй үйл ажиллагаа, иргэдийн мэдлэг, мэдээлэл дутмаг байгаа зэрэг шалтгаанаас орон нутагт салбарын үйл ажиллагааг эрхлэх болон төрийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангахад багагүй бэрхшээл тулгарч байна.

Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд аймаг орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд төдийлөн хувь нэмэр оруулахгүй байгаа нь уул уурхайн үйл ажиллагааг дэмжихгүй байх шалтгаан болж байна.

Иймд “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого - Алсын хараа 2050”, “3 тулгуурт хөгжлийн бодлого”, “Дундговь аймгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр”, “Дундговь аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д суурилсан “Дундговь аймгийн уул уурхай, эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын хүрээнд эрдэс түүхий эдийн нөөцийг зүй зохистой ашиглах, байгаль орчинд хал багатай, өндөр технологид тулгуурлан Дундговь аймгийн хөгжилд нөлөө үзүүлэхүйц ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг ашиглан, орон нутгийн санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх, төрийн байгууллага, иргэд болон уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, иргэдэд мэдлэг мэдээлэл олгох, тэдний сэтгэлгээг өөрчлөх шаардлага гарч байна.

### **Хоёр: Уул уурхай, эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын зарчим**

Уул уурхайн салбарын нөлөөгөөр газарзүйн байршлаас үл хамааран байгаль орчин, нийгмийн бүтцэд өөрчлөлт ордог. Энэ нь мөн тухайн газар нутгийн байгалийн тогтоц, ард иргэдийнх нь амьжиргаанд нөлөөлнө. Хариуцлагатай уул уурхайг тодорхойлогч цөм болох

- Тухайн нутгийн байгаль экологи, түүх соёлын өвийг хадгалах шаардлагыг ойлгох
  - Байгаль орчинд ээлтэй уурхайн ашиглалтыг хэрэгжүүлэх
  - Уурхайг ашиглах нь ажилчид болон уурхайн бүсэд харьяалагдах ард иргэдэд эерэгээр нөлөөлөх
  - Засаглалын зохистой бүтэцтэй байх
- гэсэн дөрвөн үндсэн зарчимд тулгуурлан

2.1. Уул уурхай, эрдэс баялагийн салбарын хөрөнгө оруулагч, үйл ажиллагаа эрхлэгч нь хууль дээдлэх, харилцан ашигтай ажиллах, компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэх

2.2. Байгаль орчинд ээлтэй, түүх соёл болон хүн, малын эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй стандартад нийцсэн дэвшилтэт техник, технологийг ашиглаж ил тод, хариуцлагатай уул уурхайн зарчимд нийцсэн үйл ажиллагаа явуулах төслийг дэмжих

2.3. Бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээг олон нийтэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй байлгах

2.4. Бодлогыг хэрэгжүүлэхэд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, салбарын аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангаж, хамтран ажиллах

### **Гурав. Бодлогын хэрэгжих хугацаа.**

3.1. Бодлогын баримт бичиг нь 2020-2025 он хүртэл Дундговь аймгийн нутаг дэвсгэрт хэрэгжинэ.

### **Дөрөв. Бодлогын зорилго.**

4.1. Аймгийн хариуцлагатай уул уурхайн салбарыг хөгжүүлж, аж үйлдвэрлэлийн салбарын Дотоодын нийт бүтээгдэхүүн ДНБ 2018 онд 53,839.8 сая төгрөг байгааг 2025 онд 72,068.2 сая төгрөгт хүргэнэ.

## **Тав. Уул уурхай, эрдэс баялагийн салбарт баримтлах бодлогын зорилт**

5.1. Уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн салбарын ДНБ 2018 онд 1,443.0 сая төгрөг байгааг 2025 онд 5,000.0 сая төгрөгт хүргэнэ.

5.2. Уул уурхайн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийн ДНБ-ийг 2025 он гэхэд 3,000.0 сая төгрөгт хүргэнэ.

5.3. Байгаль орчинд хал багатай технологи бүхий уул уурхайг дэмжиж, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн нийт газарт ногдох нөхөн сэргээсэн талбайн эзлэх хувь 2018 онд 7.5 байгааг 2028 онд 37.5-д хүргэнэ.

5.4. Шаардлагатай газруудад шинээр ашигт малтмалын орд илрүүлэх боломжийг бүрдүүлж, геологийн судалгаа, эрдэс баялгийн эрэл хайгуулын ажлыг өргөтгөж, судлагдсан газар нутгийн талбайг 90%-д хургэнэ.

### **Бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ:**

*5.1. Уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн салбарын ДНБ 2018 онд 1,443.0 сая төгрөг байгааг 2025 онд 5,000.0 сая төгрөгт хүргэх зорилтын хүрээнд:*

5.1.1. Орчин үеийн өндөр технологид тулгуурласан уул уурхайн олборлох үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;

5.1.1.1. “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад орсон аймгийн эдийн засгийн хөгжилд ач холбогдол өгөх Дэлгэрхангай сумын Ширээ уулын гөлтгөнийн, Баянжаргалан, Өндөршил сумын Өвдөг худгийн, Баянжаргалан сумын Хөөтийн хонхор, Сайнцагаан сумын Тэвшийн говийн нүүрсний ордуудыг стратегийн ач холбогдолтой ордоор батлуулах асуудлыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлнэ.

5.1.1.2. “Дундговь аймгийн хөгжилд нөлөө үзүүлэхүйц ач холбогдол бүхий орд”-ын жагсаалтыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулж, шийдвэрлүүлнэ.

5.1.2. Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн нийгмийн хариуцлагын хүрээнд байгуулсан хөгжлийн сангаар дамжуулж, жил бүр орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих, орон нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах, байгаль орчныг хамгаалахад зориулж 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийнэ.

5.1.2.1. Салбарын хөрөнгө оруулагчдыг орон нутагт ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэн, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, аймаг, сумын хамтран ажиллах 3 талт гэрээ байгуулж ажиллана.

5.1.2.2. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй бүх аж ахуйн нэгжүүдийг орон нутгийн татварын албанд бүртгэлтэй болгох, эсвэл аймагт охин компани байгуулж үйл ажиллагаа явуулах шаардлага тавьж хэрэгжүүлнэ.

5.1.2.3. Улс болон бүс нутгийн хэмжээнд нөлөө үзүүлэхүйц орон нутгийн компани бий болгож уул уурхайн үйлдвэрлэлийг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ.

5.1.2.4. Ашигт малтмалын салбарын “Шилдэг хөрөнгө оруулагч”, “Шилдэг хууль сахигч”, “Шилдэг экспортлогч” аж ахуйн нэгжүүдийг жил бүр шалгаруулж алдаршуулна.

5.1.2.5. Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөөс уул уурхайн чиглэлээр гадаад, дотоодын их дээд сургуульд суралцах хүсэлтэй сурагчдын зардлыг ашиглалт явуулж буй аж ахуйн нэгжүүдээр дэмжүүлж нутгийн боловсон хүчнийг бэлтгэнэ. /Хөгжлийг дэмжих сангаас/

5.1.2.6. Аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд уул уурхайн мэргэжилтэн бэлтгэх ангиудыг нээж ажиллуулна.

5.1.2.7. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд ажиллагсдын 50-аас доошгүй хувийг орон нутгаас авч мэргэшүүлэн ажиллуулна.

5.1.3. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд жилд 2-оос доошгүй удаа нутгийн захиргааны болон хууль хяналтын байгууллагуудын нэгдсэн шалгалт явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж тодорхой ажил зохион байгуулна.

5.1.3.1. Ашигт малтмалын хууль бус, хулгайн олборлолттой тэмцэх чиг үүрэг бүхий шуурхай хяналтын багийг аймгийн Засаг даргын тамгын газар, Мэргэжлийн хяналт, Цагдаа, Прокурор, Тагнуул, Онцгой байдал, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын бүрэлдэхүүнтэй байгуулж, ажиллах журмыг батлан мөрдөж ажиллана.

5.1.3.2. Бичил уурхайн үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомж, журам, зааврын дагуу зохион байгуулж, ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, олборлолтоос олсон орлогыг аль болох тухайн сумын нийт иргэд жигд хүртэж байх тогтолцоог бүрдүүлнэ.

5.1.3.3. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас баталсан уул уурхайн бүтээгдэхүүний нэгдсэн маршрутын хүрээнд уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийг аж ахуйн нэгж тус бүрээр аймгийн Засаг даргын баталсан маршрутын дагуу хийлгэж, сайжруулсан болон хатуу хучилттай автозам барих шаардлагыг тавьж ажиллана.

5.1.4. Салбарын бодлогыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хангаж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийг салбарын мэдээ мэдээллээр хангаж, нээлттэй, ил тод байх нөхцөлийг бүрдүүлнэ.

5.1.4.1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлж, уул уурхай, эрдэс баялгийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт, гүйцэтгэсэн ажлын тайлан, татвар төлбөр зэргийг хамарсан “Мэдээллийн сан” бий болгож жил бүр баяжуулан аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, иргэдийг мэдээллээр хангана.

5.1.4.2. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн орон нутагтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг зохион байгуулахад нутгийн иргэдийн оролцоог хангана.

5.1.4.3. Холбогдох оролцогч талуудтай хамтран салбарын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаа, үр дүн, орлого, зарлага, татвар, төлбөр, хураамжаа олон нийтэд ил тод мэдээлэх чиглэлээр уулзалт ярилцлага, зөвлөгөөн, сургалт, семинарыг зохион байгуулж хэвшинэ.

5.1.4.4. Салбарын талаар мэдээллийг иргэдэд хүргэх, орон нутгийн сонин хэвлэл, телевиз, цахим хуудсаар тогтмол мэдээллэнэ.

5.2. Уул уурхайн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийн ДНБ-ийг 2025 он гэхэд 3,000.0 сая төгрөгт хүргэх зорилтын хүрээнд:

5.2.1. Уул уурхайн боловсруулах үйлдвэрлэл явуулах, эцсийн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж ахуйн нэгжүүдийг дэмжих;

5.2.1.1. Эрдэнэдалай сумын Оюут овооны төмөр, Баянжаргалан сумын Хараат, Эрээний төмөр, Говь-Угтаал сумын Зүүн тойром, Төмөртэй, Хараатын хар тугалга, цайрын ордуудыг түшиглэн төмөр, өнгөт металл боловсруулах үйлдвэр байгуулах боломжийг судалж шийдвэрлэнэ.

5.2.1.2. Гурвансайхан сумын Салхитын мөнгөний ордыг ашиглахад орон нутгийн оролцоог нэмэгдүүлж, ордын тодорхой хувийг /51 хүртэлх/ орон нутагт эзэмших асуудлыг Засгийн газар, Улсын Их Хуралд тавьж шийдвэрлүүлнэ.

5.2.1.3. Тэвшийнговь, Хөөт, Цагаан-Овоо, Өвдөг худаг, Лог үнст зэрэг нүүрсний ордуудын олборлолтыг нэмэгдүүлж, нүүрсийг гадаад дотоодын зах зээлд гаргах, нүүрсийг боловсруулах, хийжүүлэх, шингэн түлш гаргах үйлдвэр байгуулах зэрэг санал санаачлагыг бүх талаар дэмжинэ.

5.2.1.4. Нүүрс-химийн судалгааны лабораторийг орон нутагт байгуулах асуудлыг судалж шийдвэрлэнэ.

5.2.1.5. Баянжаргалан сумын Хавирга, Их бичигт, Хөх дэл, Сүүл өндөр, Хөх тээг, Бумбатын хайлуур жоншны ордуудыг түшиглэн жоншны баяжуулах үйлдвэр байгуулах, хагас болон бүрэн боловсруулсан баяжмал гаргаж экспортлох боломжийг бүрдүүлнэ.

5.2.1.6. Гурвансайхан сумын Хөтөл цагааны гантигийн ордыг түшиглэн чулууны үйлдвэр, будгийн үйлдвэр байгуулах боломж нөхцөлийг судалж шийдвэрлэнэ.

5.2.1.7. Дэлгэрхангай сумын Тарагт, Ширээ уулын гөлтгөнийн ордыг түшиглэсэн бага оврын цементийн үйлдвэр байгуулахыг судалж шийдвэрлэнэ.

5.2.1.8. Түгээмэл тархацтай ашигт малтмал болох боржин элс, шавар, зос, хайрганы ордуудыг түшиглүүлэн стандартын шаардлага хангасан барилгын түүхий эд материал бэлтгэх үйлдвэр байгуулна.

*5.3. Байгаль орчинд хал багатай технологи бүхий уул уурхайг дэмжиж, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн нийт газарт ногдох нөхөн сэргээсэн талбайн эзлэх хувь 2018 онд 7.5 байгааг 2028 онд 37.5-д хүргэх зорилтын хүрээнд;*

5.3.1. Уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийн дүйцүүлэн хамгааллаар уул уурхайн улмаас эвдэрч, ухагдсан эзэнгүй орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийлгэх.

5.3.2. Уул уурхайн улмаас эвдэрсэн, нөхөн сэргээх шаардлагатай талбайг эзэн холбогдогчоор нь нөхөн сэргээлгэх.

*5.4. Шаардлагатай газруудад шинээр ашигт малтмалын орд илрүүлэх боломжийг бүрдүүлж, геологийн судалгаа, эрдэс баялгийн эрэл хайгуулын ажлыг өргөтгөж, судлагдсан газар нутгийн талбайг 90%-д хүргэх зорилтын хүрээнд:*

5.4.1. 1:50,000-ны масштабын геологийн зураглалын ажлыг аймгийн газар нутгийн 70%-д хүргэж, шинээр ашигт малтмалын орд илрүүлэх боломжийг бүрдүүлнэ.

5.4.2. Ард иргэдийн эрт дээр үеэс тахиж, шүтэж ирсэн уул, овоо, байгалийн үзэсгэлэнт, өвөрмөц сонин тогтоцтой болон түүх соёлын дурсгалт, хужир марзтай газрууд, эмчилгээ сувилгааны чанартай рашаан, ус зэргийг аймаг, сумын тусгай хамгаалалтад авна.

## **Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт**

### **6.1. Удирдлага, зохион байгуулалт:**

6.1.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймгийн Засаг даргын Тамгын газар нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангана.

6.1.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж, мониторинг үнэлгээ хийх, салбарын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах ажлыг аймгийн холбогдох төрийн байгууллагууд хариуцан хэрэгжүүлнэ.

6.1.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, салбарын аж ахуйн нэгжүүд, иргэд хамтран зохион байгуулна.

### **6.2. Дэд хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг дараах эх үүсвэрүүдээс санхүүжүүлнэ:**

6.2.1. Улс, орон нутгийн төсөв

6.2.2. Аж ахуйн нэгжүүд болон олон улсын хандивлагч орнуудын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

6.2.3. Хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр

### **Долоо. Хүрэх үр дүн**

7.1. Уул уурхайн олборлох үйлдвэрлэл, экспорт нэмэгдэхийн зэрэгцээ аймгийн эдийн засагт уул уурхайн салбарын оруулах хувь нэмэр өсөн нэмэгдэж, уул уурхайн үйлдвэрүүдийг дагаж орчин үеийн дэд бүтэц бий болно.

7.2. Уул уурхайн салбарт ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа тогтворжиж, ажилгүйдлийн түвшин тогтвортой буурна.

7.3. Геологийн эрэл хайгуулын ажлын чанар дээшилж, аймгийн нутаг дэвсгэрт байгаа байгалийн баялгийн шинэ нөөц ордууд илэрнэ.

7.4. Ашигт малтмал, уул уурхайн салбарт тавьж буй орон нутгийн хяналт сайжирна.

7.5. Байгалийн нөөц баялгийн зүй зохистой ашиглалт, хамгаалал сайжирч, ашигт малтмалын олборлолттой холбоотой байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, элэгдэл эвдрэл буурч нөхөн сэргээлт сайжирна.

7.6. Хариуцлагатай уул уурхай хөгжиж, нийгмийн хариуцлагаа ухамсарласан, орон нутагтай хамтын ажиллагаатай хуулийн этгээд бий болно.

7.7. Уул уурхайн аж ахуйн нэгжүүд, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд хоорондын хамтын ажиллагаа өргөжнө

7.8. Байгаль орчин, уул уурхайн салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилт сайжирч, ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод, хүртээмжтэй болно.

7.9. Салбарын талаар иргэдийн мэдлэг, мэдээлэл нэмэгдэж хандлага өөрчлөгдсөн байна.

#### **Найм. Хяналт шинжилгээ, үнэлгээ**

8.1. Сумдын Засаг даргын Тамгын газар тухайн сумын хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, ажлын тайланг жил бүрийн 2 дугаар сарын 20-ны өдрийн дотор багтаан аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

8.2. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт шинжилгээ-үнэлгээ хийж, дүнг аймгийн Засаг даргын зөвлөл, Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд танилцуулна.

## **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС**